

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 03 дугаар сарын 21

№\_\_

Улаанбаатар хот

*“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай”*

Компанийн тухай Хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 69.3, 69.6, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2.1, 2.3, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-ийг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”)-ыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө, 3-р хороо, Улсын Их Дэлгүүрийн 7 давхарын уулзалтын өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
  - Нэг.** Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - Хоёр.** Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - Гурав.** Компанийн 2024 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
  - Дөрөв.** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. ХЭЭХ-г хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн дотор зохих баримт бичгийн хамт хүргүүлсүгэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр байхаар тогтоосугай.
5. Хурал зохион байгуулах комисст дараах нэр бүхий хүмүүсийг томилсугай:
  - i. Гүйцэтгэх захирал Я.Нэргүй

- ii. Хуульч С.Батчимэг
  - iii. Хуульч А.Солонго
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-н дагуу баталж, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн дотор өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, бүртгэл, хаяг нь тодорхой хувьцаа эзэмшигч нарт бичгээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасгай.
  7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлын хүрээнд Компанийн хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгүүдийн жагсаалтыг, эдгээр баримт бичгийг бэлэн болгох боломжтой хугацааны хамт Хавсралт №2-р тогтоож, ажлын өдрүүдэд 09:00 цагаас 18:00 цагийн хооронд Компанийн байранд хүрэлцэн ирж танилцах эрхтэй блоохыг дурьдсугай.
  8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Я.Нэргүй, Тооллогын комиссын даргаар С.Батчимэг, гишүүнээр А.Солонго нарыг тус тус томилсугай.
  9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №3-р баталсугай.
  10. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ҮЦТХТ ХХК-ийн бүртгэлд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн Хавсралт №4-р баталсугай.
  11. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, гаргасан дүгнэлтийг Хавсралт №5,6-р баталсугай.
  12. Санхүүгийн Зохицуулах Хорооны журмын дагуу саналын хуудсаар санал өгч болох бөгөөд инйхүү санал өгөх сүүлийн хугацаа нь 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14:00 цаг хүртэл байна. Саналын хуудасны загварыг Хавсралт №7,8-р баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГОНГОР

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 03 дугаар сарын 21

№ 02

Улаанбаатар хот

*“Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн  
талаарх дүгнэлтийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн  
хуралд танилцуулж, батлуулах тухай”*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-ийг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, гаргасан дүгнэлтийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Д.ГОНГОР

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 03 дугаар сарын 21

№ 03

Улаанбаатар хот

*“2023 оны үйл ажиллагаанд ногдол  
ашиг хуваарилах эсэх асуудлаар”*

Компанийн тухай Хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-ийг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

